



Баян-Олгий аймгийн тов талбайг шинэчлэн тохижуулж байна. Аймгийн ЗДТГ, ИТХ-ын цагаан байшингийн омно талд оршдог энэ талбайд цайвар онгийн гантиг дэвсэн, цэцгийн хуаран, усан оргилуур байгуулах зэргээр гоёх юм байна.

Ингэж засахдаа, монгол, орос дайчдыг хүндэтгэн Ардын хувьсгалын ялалтанд зориулж 1957 онд босгосон хошоог буулгажээ. Уг хошооний нээлтийн ёслолын ажиллагаанд Монгол Улсын баатар, генерал Б.Дорж, ОХУ-аас Монгол Улсад сууж байсан Онц богоод Бүрэн эрхт элчин сайд В.М.Молотов нарын хүндэт толоологчид оролцсон түүхтэй.

Энэ талбайг доктор Х.Зардыхан ном зохиолууддаа «Б.Хабийгийн нэрэмжит талбай» хэмээн нэрлэсэн боловч албан ёсоор тийм нэр олгогдоогүй. Гэхдээ УБХ-ын гишүүн, аймгийн анхны дарга, торийн нэрт зүтгэлтэн Б.Хабийн нэрэмжит болгох нь зүй ёсны асуудал гэж иргэд үздэг байсан юм.